



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

### Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, б нэрийн нийт 60,819,674.30 (жаран сая найман зуун арван есөн мянга зургаан зуун далан дөрвөн төгрөг гучин мөнгө) төгрөгийн балансын үнэ 1,908,556.20 (нэг сая есөн зуун найман мянга таван зуун тавин зургаан төгрөг хорин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Зам, тээврийн хөгжлийн яам, Хүнс хөдөө аж ахуй Хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Θ.Лувсанренчин, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн  
105 дугаар тогтолцын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛДЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Ашиглах хугацаа /жилзэр/	Балансын нийт үнэ		Хуимтлагдсан элэгээл (төгрөг)	Үлдэгээл үнэ	Шилжүүлэн авах байгууллага
					Балансын нийт үнэ	Хуимтлагдсан элэгээл (төгрөг)			
1	Галын дохиоллын систем	12/31/2020	1	15	16,080,182.80	264,331.80	15,815,851.00	Эрүүл мэндийн яам	
2	Цахилгааны самбар	12/31/2020	3	10	5,166,810.00	387,860.70	4,778,949.30		
3	Галын дохиоллын систем	12/31/2020	1	15	15,726,914.50	258,525.00	15,468,389.50	Хүнс хөдөө аж ахуй Хөнгөн үйлдвэрийн яам,	
4	Цахилгааны самбар	12/31/2020	2	10	3,444,540.00	258,573.80	3,185,966.20		
5	Галын дохиоллын систем	12/31/2020	1	15	13,512,147.00	222,117.30	13,290,029.70	Зам тээврийн хөгжлийн яам.	
6	Цахилгааны самбар	12/31/2020	4	10	6,889,080.00	517,147.60	6,371,932.40		
					60,819,674.30	1,908,556.20	58,911,118.10		
					(жаран сая найман зуун арван есөн мянга зургаан зуун далан дөрвөн төгрөг гучин мөнө)	(нэг сая есөн зуун найман мянга таван зуун тавин зургаан төгрөг арван найман төгрөг арван мөнө)	(тавин найман сая есөн зуун арван нэгэн мянга нэг зуун арван найман төгрөг арван мөнө)		
								НИЙТ ДҮН	